

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын
Ерөнхий захирлын 2017 оны 05 дугаар сарын 31-ний
өдрийн 37 тушаалын хоёрдугаар хавсралт



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН "НАЙРАМДАЛ" ЦОГЦОЛБОРЫН АЖИЛТНУУДЫН ЁС ЗҮЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Олон Улсын Хүүхдийн "Найрамдал" цогцолборын ажилтан /цаашид "ажилтан" гэх/ нь байгууллагын эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргээ биелүүлэхдээ баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэхэд энэ журмын зорилго оршино.
- 1.2. Энэхүү журам нь ажилтнуудыг тухайн ажлын байранд хариуцсан ажил, үүргээ чанд биелүүлэх, аливаа зөрчил, гажуудлаас сэргийлэх, үйлчлүүлэгч, харилцагч болон хамтран ажиллагсадтайгаа зөв боловсон харилцах, тэдний нэр төрийг эрхэмлэн хамгаалахад чиглэгдэнэ.

Хоёр. Ёс зүйн зарчим

- 2.1. Цогцолборын ажилтан нь үйл ажиллагаандаа "Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм", "Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрэм"-д зааснаас гадна Хүүхдийн эрхийг хамгаалах хуулийн ёс зүйн зарчмуудыг баримтална. Үүнд:
 - 2.1.1 Шударга ёсны
 - 2.1.2 Хууль дээдлэх
 - 2.1.3 Тэгш байдал
 - 2.1.4 Хариуцлага хүлээх
 - 2.1.5 Олон нийтэд үйлчлэх
 - 2.1.6 Хүүхдийн эрхийг дээдлэх

Гурав. Ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс ба хэм хэмжээ

- 3.1 Цогцолборын ажилтнууд нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хуулиар тогтоосон төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүрэг, Хүүхэд хамгааллын талаар баримтлах бодлогын баримт бичиг болон дараах ёс зүйн хэм хэмжээг удирдлага болгон сахин биелүүлэх үүрэгтэй.
- 3.2 *Ажилтан нь шударга ёсны зарчмын хүрээнд:*
 - 3.2.1 Албан үүргээ гүйцэтгэхдээ хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлж ажиллана.
 - 3.2.2 Хөдөлмөрийн хууль, цогцолборын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашиглана.